

“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 07 дугаар сарын 21

Улаанбаатар хот

Д/Д	Арга хэмжээ	Төсөв (сая төг)		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хэрэгжилт	Хүрсэн түвшин, гүйцэтгэ-лийн хувь
		Төсөвлөсөн	Гүйцэтгэл /зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)		Он	Түвшин	Он	Түвшин		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	2.7.3.гадаа-дын иргэн, харьяалал-гүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалах, хяналт тавих тогтолцоог бэхжүүлнэ.	-	-	Гадаадын иргэн, харьяалал-гүй хүн, цагаачдын тооны харьцаа	2024	2024 онд Монгол Улсад цагаачлан оршин суугч нийт 1827 гадаадын иргэн байсан нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан хэмжээнээс хэтрээгүй.	2025	Хуулийн хүрээнд зохист түвшний хязгаарыг алдагдуу-лахгүй байх	Монгол Улсад 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 1815 гадаадын иргэн, үүнээс хамгийн их буюу БНХАУ-ын 1226 иргэн цагаачлан оршин суухаар бүртгэлтэй байгаа нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасан хэмжээнээс хэтрээгүй байна. https://opendata.gov.mn/ Монгол Улсад 2009-2012 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай УИХ-ын 2009 оны 44 дүгээр тогтоолоос хойш тогтоолыг шинэчлэн батлаагүй бөгөөд Гадаадын иргэн, харьяатын газраас “Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай” УИХ-ын тогтоолын төсөл, танилцуулгыг 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/1730 дугаар, 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/2075 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлж байсан.	

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
									Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Монгол Улс нь гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сантай байна гэсний дагуу “Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан” (isf.mn) системийг 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, гадаадын иргэний визийн зөвшөөрөл, виз, оршин суухтай холбоотой мэдээллийг бүртгэх, хяналт тавих, зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг шуурхай хангах боломжийг бүрдүүлэн холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, уг сангийн мэдээлэлд бүртгэлээр хяналт тавин ажиллаж байна. “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системийг ашиглалтад оруулснаас хойш 845 удаагийн засвар, шинэчлэлийг хийж, хөгжүүлэлтийг сайжруулан визийн зөвшөөрөл, виз, оршин суух зөвшөөрөл, оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгалт, оршин суух зөвшөөрлийн хасалт, оршин суух зөвшөөрлийн хэлбэр өөрчлөлт, паспортын мэдээлэл өөрчлөлт, оршин суух зөвшөөрлийн хаягийн өөрчлөлт, оршин суух үнэмлэх дахин авах, гадаадын иргэний бүртгэлтэй холбоотой нийт 95,420 удаагийн хүсэлтээр 185,493 иргэний баримт материалыг хүлээн авч тус тус хянан шийдвэрлэлээ. Системийн санхүүжилтийг 2022 онд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас шийдвэрлэсэн бөгөөд хөгжүүлэлтэд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно. Хууль зүй дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/98, А/25 дугаар хамтарсан тушаалаар “Гадаадын иргэний виз, бүртгэл,	

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
									мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах, мэдээлэл нийлүүлэх, солилцох журам"-ыг батлан мөрдөж байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/24 дүгээр тушаалаар баталсан "Салбарын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам", байгууллагын даргын 2021 оны А/173 дугаар тушаалаар баталсан "Гадаадын иргэн, харьяатын газрын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх журам"-ын дагуу гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын мэдээг сар бүр, хагас жил тутам гарган харьцуулсан дүгнэлт хийж дээд шатны байгууллагад тайлагнаж байна.	
2	7.2.4.гадаа-дын иргэдийг улсын хилээр нэвтрэх үед биеийн давхцахгүй өгөгдлийг авч, нэгдсэн санд бүртгэх тогтолцоог бүрдүүлнэ.	-	-	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийн хөгжүүлэлт	2024	Программ хангамж, тоног төхөөрөмжийн тоо-1	2025	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт "Албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд түүнийг харьяалах улсын товчлол, төрсөн он, сар, өдөр, хүйс зэрэг өгөгдлийг багтаасан хоорондоо давхцахгүй бүртгэлийн дугаарыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно гэж" заасны дагуу бүртгэлийн системийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүлснээс хойш нийт 926,454 гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгосон байна. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 2020 оны нэмэлт өөрчлөлтөөр гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байх зохицуулалтыг тусгаснаар уг санг шинээр үүсгэн ГХЯ, ХХЕГ, ГИХГ хоорондоо мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэн Хил хамгаалах байгууллагын системтэй 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс сервис холбож, гадаадын иргэн хилээр нэвтрэх үед бүртгэлийн дугаар шууд үүсэх боломжтой болсон. Түүнчлэн энэ нэгдсэн сан нь ХХЕГ-ын Зорчигчийн мэдээллийн сантай	

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
									холбогдсоноор гадаадын иргэнд тавих хяналт сайжрахын зэрэгцээ, төрийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа хурдан шуурхай, үр дүнтэй боллоо. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, И-Монгол академитай хамтран 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс танилт нэвтрэлтийн ДАН системд гадаадын иргэний бүртгэл (F-Register) ашиглан нэвтрэх, тоон гарын үсэг авах боломжийг бүрдүүлсэн. Бүртгэлийн дугаарын мэдээллийг 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 22 байгууллагад төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан өгч байна.	
Үнэлгээ ... хувь										

--oo0oo--